

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ТЭРГҮҮЛЭГЧИД, ТҮҮНИЙ АЖЛЫН АЛБАНААС 2016 ОНД ЗОХИОН
БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН**

2016.12.05

Улаанбаатар хот

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд зааснаар дүүргийн Хурал нь тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй байдаг.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Хүний хөгжилд тулгуурласан, Төр иргэний хамтын ажиллагаанд суурилсан дүүргийн нийгэм, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангасан нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлэх зорилго тавьж, үйл ажиллагаандаа ил тод, нээлттэй, шударга, тэгш байдлын зарчмыг баримтлан ажиллаж байна.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Тэргүүлэгчид түүний Ажлын албанаас 2016 онд Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааг иргэдэд ойртуулж, хороодын Иргэдийн Нийтийн Хурлын чадавхийг дэмжих, Иргэний танхимаар дамжуулан иргэдийн оролцоог дээшлүүлэх зорилтыг дэвшүүлэн, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа.

Энэ 2016 онд Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлыг сонгох сонгууль болж, сонгуулийн үр дүнд 7 дахь удаагийн дүүргийн Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага үйл ажиллагаагаа эхэлсэн онцлог жил байлаа.

Ингээд дэвшүүлсэн зорилтын хүрээнд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчид түүний Ажлын албанаас 2016 онд зохион байгуулсан ажлын тайланг Та бүхэнд тоймлон танилцуулж байна.

**Нэг. ХУРЛЫН ХУРАЛДААН, ХУРЛЫН ХОРООДЫН ҮЙЛ
АЖИЛЛАГАА, ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ АЖИЛЛАСАН ТАЛААР:**

Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд тайлант хугацаанд Хурал, Тэргүүлэгчид нийт 19 удаа хуралдаж, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгагдсан хөтөлбөр, төсөл арга хэмжээний чиглэлээр 6, хяналт шалгалтын чиглэлээр 35, бусад ажлын чиглэлээр 10 нийт 66 асуудлыг хэлэлцэн, 66 тогтоол шийдвэр гаргасан ба нийт 5 заалт бүхий үүрэг чиглэлийг дүүргийн Засаг дарга түүний Тамгын газарт өгч, хэрэгжилтийг дүгнэн ажиллалаа.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийг сонгох 2016 оны орон нутгийн сонгуулийн үр дүнд шинээр сонгогдсон Хурлын Төлөөлөгчдийн

Анхдугаар хуралдааныг зохион байгуулж, хуралдааны хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс Хурал болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, хурлын шийдвэрийн биелэлтийг хянан шалгах, цаг үеийн асуудлыг судлах, санал дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий Хурлын хороог шинээр байгуулан ажиллуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллалаа.

Хурлын Тэргүүлэгчдээс 2016 онд хяналт шалгалтын ажлын чиглэлээр Хурлын хороодоос зохион байгуулах ажил, хэлэлцэх асуудлын сэдэвчилсэн төлөвлөгөөг батлан, Хурлын хороо хариуцсан нарийн бичгийн дарга нарт чиглэл, заавар, зөвлөмж өгч ажилласан.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороод тайлангийн хугацаанд Хурлын даргын баталсан удирдамжаар хяналт шалгалт, хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан нийт 2 удаа хуралдсанаас; Эрх зүй, Нутгийн удирдлагын хороо 2 удаа, Ногоон хөгжил газрын харилцааны хороо 2 удаа, Дэд бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хороололын хөгжлийн хороо 2 удаа, Нийгмийн хөгжлийн хороо 2 удаа, Ес зүй, өргөдлийн хороо 3 удаа, Төсвийн зарцуулалтын хяналтын хороо 2, Эдийн засаг, төсвийн хороо 2 удаа тус тус хуралдаж, танилцсан ажлын чиглэлээр санал дүгнэлт гарган ажиллалаа.

Хурлын хороод хяналт шалгалтын ажлын чиглэлээр дараах ажлуудын явц байдал, гүйцэтгэлтэй танилцсан байна. Үүнд:

- *Эрх зүй, Нутгийн удирдлагын хороо*: Дүүргийн Засаг даргын 2017-2020 он хүртлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Дүүргийн эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтын хэрэгжилт, Дүүргийн 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн харьяалах асуудлаар, Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны 2017-2020 он хүртэлх хөтөлбөр;

- *Нийгмийн хөгжлийн хороо*: Дүүргийн Засаг даргын 2017-2020 он хүртэлх үйл ажиллагааны хөтөлбөр, Дүүргийн эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтын хэрэгжилт, Дүүргийн 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн харьяалах асуудлаар;

- *Хот байгуулалт, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хороо*: Дүүргийн Засаг даргын 2017-2020 он хүртэлх үйл ажиллагааны хөтөлбөр, Дүүргийн эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтын хэрэгжилт, Дүүргийн 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн харьяалах асуудлаар;

- *Ногоон хөгжил, газрын харилцааны хороо*: Дүүргийн Засаг даргын 2017-2020 он хүртлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Дүүргийн эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтын хэрэгжилт, Дүүргийн 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн

чиглэлийн харьяалах асуудлаар, Дүүргийн газар зохион байгуулалтын 2016 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө;

- *Төсвийн зарцуулалтын хяналтын хороо*: Дүүргийн 2015 оны төсвийн гүйцэтгэл, Дүүргийн 2016 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай, Дүүргийн эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтын хэрэгжилтийн харьяалах асуудлаар;

- *Эдийн засаг, төсвийн хороо*: Дүүргийн 2017 оны төсөв, Дүүргийн Засаг даргын 2017-2020 он хүртлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Дүүргийн 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн харьяалах асуудлаар;

- *Ёс зүй, өргөдлийн хороо*: Дүүргийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлт, Дүүргийн иргэний танхимын үйл ажиллагаа, Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн хорооны үйл ажиллагаа зэрэг болно.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Ажлын алба, Хурлын Төлөөлөгчдийн ажиллах нөхцөл бололцоог нь хангаж, дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэхэд нь тусалж, тэдний үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсөвт тусгуулах, тухайн жилд хийгдэх дүүргийн нийгэм, эдийн засгийн зорилт, төсөв төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллалаа.

Нутгийн өөрөө удирдах байгууллагыг чадавхжуулах чухал асуудлын нэг нь иргэдээ төлөөлөн итгэлийг нь хүлээн сонгогдсон Төлөөлөгч нарыг чадваржуулах асуудал юм.

Шинээр бий болсон Хурлын Төлөөлөгч нарт шинэ мэдээ мэдээлэл олгох, чадавхжуулах зорилгоор МНУХ-той хамтран “Хурал ба Төлөөлөгчдийн манлайлал, ур чадвар” сэдэвт сургалтыг зохион байгуулж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаатай танилцах өдөрлөг, нөхөрсөг тэмцээнд Хурлын төлөөлөгчдийн баг бэлтгэн амжилттай оролцлоо.

Мөн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид нэртэй групп нээж хурал, чуулганы зар, мэдээг тухай бүр цахимаар болон утсаар хүргэж Төлөөлөгчдийн оролцоог хангаж ажиллаж байна.

Орон нутгийн хурлын ээлжит сонгуулиар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд шинээр сонгогдсон нийт 35 албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор хүлээн авч бүртгэж баталгаажууллаа.

Хоёр. ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛ, ИРГЭНИЙ ОРОЛЦОО, ИРГЭНИЙ ТАНХИМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын томоохон зорилтын нэг нь анхан шатны Хурлын байгууллагыг бэхжүүлэх, чадавхжуулах явдал юм.

Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааг тогтмолжуулах, Хурлын дарга нарын ажлын уялдаа холбоог сайжруулах, харилцан мэдээ, мэдээлэл солилцох,

тэднийг сургалт арга зүйгээр хангах зорилгоор 13 удаагийн зөвлөгөөнийг зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.

Түүнчлэн Хорооны Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааг чадавхжуулах ажлын хүрээнд нийт 3 удаагийн сургалт, арга хэмжээг зохион байгуулсан ба Хороодын Иргэдийн Нийтийн Хурал зохион байгуулахтай холбогдуулан хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга нарыг арга зүйн “Зөвлөмж” гарын авлагаар хангаж ажиллалаа.

Түүнчлэн Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлэх, хороодын Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааг идэвхжүүлэх, мэдээ мэдээллээр хангах, үр дүн хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилгоор хороодын Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн зөвлөлдөх уулзалтыг 2016 оны 04 сарын 13-ны өдөр Чингэлтэй зохион байгууллаа.

Тус уулзалтаар дүүргийн ГХУСАЗ салбар зөвлөлийн үйл ажиллагаа, цаг үеийн бусад мэдээ мэдээлэл өгөхөөс гадна Монгол Улсын Их Хурал, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдуулан шинээр баталсан Сонгуулийн тухай хуулийн танилцуулга, хэлэлцүүлгийг Монголын хуульчдын холбоотой хамтран зохион байгуулж, хууль, гарын авлагаар хангаж ажиллалаа. Уулзалт хэлэлцүүлэгт 19 хорооны 77 Иргэдийн Нийтийн Хурлын дарга, Тэргүүлэгчид хамрагдсан байна.

Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааг чадавхжуулах хүрээнд зохион байгуулсан ээлжит арга зүйн сургалтыг Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хороотой хамтран “Сум дүүргийн сонгууль зохион байгуулах цагийн хуваарь” сэдвийн хүрээнд зохион байгууллаа. Тус сургалтаар Сонгуулийн тухай хууль тогтоомж, сонгууль зохион байгуулахтай холбоотой зүйл заалтууд холбогдох дүрэм, журам, сонгуулийн сурталчилгаа түүнд хяналт тавих асуудлуудыг харилцан ярилцаж, мэдээлэл солилцсон юм.

Иргэдэд болон тухайн орон нутагт тулгамдаж буй асуудлаар иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, цаг үеийн болон шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, дүүрэг, хорооноос зохион байгуулж буй үйл ажиллагаа, цаашид авах арга хэмжээний талаар санал солилцох зорилгоор Иргэний танхимын ажилтнуудыг дүүргийн айл өрх, иргэдтэй хийх уулзалтыг зохион байгуулсан ба тайлант хугацаанд нийт 3655 өрхтэй уулзаж, мэдээ, мэдээлэл хүргэн ажилласан байна.

Иргэдийг мэдээ мэдээллээр хангах, гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн талаар холбогдох байгууллагуудад шуурхай мэдээллэх зорилгоор Жи-мобил, Юнител, Мобиком, Скайтел зэрэг 4 үүрэн холбооны утсыг Иргэний танхимын ажилтнууд дээр ажиллуулж, “Та дохь, Бид залгая” сурталчилааны хуудсыг хэвлүүлэн дүүргийн айл өрхөд хүргүүлж, сурталчилан ажиллалаа.

Тайлант хугацаанд дээрх утсаар нийт 629 удаагийн зөрчлийн талаарх мэдээ, дуудлага ирүүлсэнийг холбогдох албан тушаалтанд шуурхай хүргэсэн ба 3238 иргэн тус утсанд мэдээ, мэдээлэл, санал хүсэлт ирүүлсэн байна.

Иргэний танхимын үйлчилгээг иргэн бүрт жигд хүргэх зорилгоор хэлтсээс иргэний танхимын тогтмол үйл ажиллагааны хуваарийг батлан эмэгтйчүүд, ахмад настан, залуучууд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, иргэдийн бүлэг, хийн дасгал,

нийтийн бүжиг, сургалт, мэдээллийн цаг гарган иргэдэд Төрийн үйлчилгээг жигд хүргэн ажиллаж байна. Иргэний танхимаар зохион байгуулсан ажлуудаас дурдвал:

Арга хэмжээ, уулзалт, хэлэлцүүлгийн чиглэлээр: Сар шинийн баярын хүндэтгэлийн арга хэмжээ, Чингэлтэйн аялгуу Ахмадын урлагийн наадам, Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын тайлангийн хуралдаан, Гудамж, байрны нийтийн эргүүлийн ажиллах журмын танилцуулга, Дотно яриа кино хэлэлцүүлэг, Иргэдээс УИХ-ын өргөдлийн байнгын хороонд өргөдөл гаргах журмын танилцуулга, Монгол гоёл 2016

арга хэмжээ, Дархан бэр хүндэтгэлийн арга хэмжээ, Миний эгчийн аврагч кино хэлэлцүүлэг, Мөрдөстэй залуу нас арга хэмжээ, Мөрдөстэй аялгуу караоке тэмцээн, Физик эмчилгээ, нөхөн сэргээх кабинетийн нээлтийн арга хэмжээ, Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хэлэлцүүлэг, Байлдагчаас хурандаа хүндэтгэлийн арга хэмжээ, Сүрьеэ, Элэгний В, С вирусны үнэ төлбөргүй оношлогоо, Нийгмийн даатгалын тухай хууль сурталчилах нээлттэй өдөрлөг, Цодгор хүү шатрын тэмцээн уралдаан зэрэг нийт 292 удаагийн /давхардсан тоогоор/ уулзалт хэлэлцүүлгийг тус тус зохион байгууллаа. Тайлант хугацаанд дээрх арга хэмжээ, уулзалт, хэлэлцүүлэгт нийт 24926 иргэн хамрагдсан байна.

Сургалт, мэдээллийн чиглэлээр: “Эдийн засгийн ил тод байдал”, “Гудамж байрны нийтийн эргүүлийг чадавхжуулах сургалт”, “Иргэдийн дуу хоолой, түүний үр нөлөө”, “Бяцхан санхүүч”, “Хөдөлмөр хэрхэн эрхлэх вэ”, “Хүүхдийн эрх ба хөгжил”, “Халдварт бус өвчнөөс алхам алхамаар сэргийлцгээе”, “Эсгий урлал, шүрэн урлал”, “Эрдэнэс таван толгойн хувьцааны сургалт”, “Илтгэх урлаг цуврал лекц”, “Өсвөр үеийнхэнд хамтарсан багийн оролцоо”, “Эрүүл дасгал хөдөлгөөн”, “Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр, учир шалтгаан”, “Хүүхдийн оролцоо ба хөгжил”, “Харилцаа”, “Гэр бүл төлөвлөлт ба нөхөн үржихүй”, “Жирэмсэн эхэд гэр үнэлгээ хийх нь”, “Бүлгийн зохион байгуулалттайгаар ногоо тариалах нь”, “Ус ба орчны эрүүл мэнд”, “Бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлье” зэрэг сэдэвт нийт 316 удаагийн /давхардсан тоогоор/ сургалтуудыг тус тус зохион байгууллаа. Тайлант хугацаанд дээрх сургалтанд 25683 иргэн хамрагдсан байна.

Тогтмол үйл ажиллагааны чиглэлээр: Долоо хоног бүрийн тогтмол өдрүүдэд “Нийтийн бүжиг”, “Хийн дасгалын цаг”, “Архины эсрэг идэвхтэй амьдрал клуб”, “Сонин унших цаг”, “Бясалгал”, “Ширээний теннис”, “Ятга”, “шатрын сургалт”-уудыг явуулж байна. Тайлант хугацаанд тогтмол үйл ажиллагаанд нийт 8911 иргэн үйлчлүүлсэн байна.

2016 онд хороодын Иргэний танхимаас зохион байгуулсан арга хэмжээнд дүүргийн 63997 иргэн хамрагдсан байна.

Гурав. ТӨВЛӨРСӨН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дэвшүүлсэн зорилт, Хурлын байгууллагын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд Тэргүүлэгчдээс баталсан төлөвлөгөөний дагуу иргэд рүү чиглэсэн, бүтээлч, үр дүн бүхий төвлөрсөн арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллалаа.

Хурал, Тэргүүлэгчдээс дэвшүүлсэн зорилт, Хурлын байгууллагын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд дараах төвлөрсөн арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

“Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль”-ийн дагуу “Эх орончдын өдөр” тэмдэглэлт өдрийг тохиолдуулан хорооны залуучуудын төлөөллийг Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, батлан хамгаалах бодлого, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, зэвсэгт хүчний үйл ажиллагаатай танилцуулах зорилгоор “Эх орон-тусгаар тогтнол” өдөрлөгийг Зэвсэгт хүчний 084 дүгээр ангид зохион байгууллаа.

Өдөрлөгийн хүрээнд “Эх орон-тусгаар тогтнол” сэдвээр лекц, чөлөөт ярилцлага хийж, байлдааны сүүлийн үеийн зэвсэг, техник, шүхрийн үзэсгэлэн үзүүлж сонирхуулсан ба залууст эх оронч үзэл санааг төлөвшүүлэхэд тус арга хэмжээний зорилго оршиж байгаа юм. Арга хэмжээнд Чингэлтэй дүүргийн 1-19 хорооны Иргэний танхимын дэргэдэх залуучуудын клубын нийт 120 залуучууд оролцлоо.

Дүүргийн хэмжээнд гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог хангах, хөршийн холбоог сайжруулах, хууль хяналтын байгууллага-иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор нийтийн эзэмшлийн гудамж, байрны нийтийн эргүүлүүдийг ажиллуулах Тэргүүлэгчдийн шийдвэр гарч, нийт 986 нийтийн эргүүлүүдэд үнэмлэхийг нь гардуулан өгч, таних тэмдэг бүхий хантааз, шаардлагатай гарын авлага, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллалаа.

Гудамж байрны нийтийн эргүүлүүдийг чадавхжуулах арга зүйн сургалтыг 2016 оны 2 удаа зохион байгуулсан ба давхардсан тоогоор 1800 нийтийн эргүүл оролцсон байна.

Гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд дүүргийн Хүүхэд, гэр бүл хөгжлийн төвтэй хамтран залуучуудын гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замын талаарх кино хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Тус хэлэлцүүлгээр гэр бүл төлөвлөлт, хүүхдээ хэрхэн сонсох вэ, гэр бүлийн зөрчил, тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ зэрэг сэдвийн хүрээнд хэлэлцүүлсэн ба залуу гэр бүл, гэр бүлийн боловсролыг дээшлүүлэхэд оршиж байгаа юм. Хэлэлцүүлэгт дүүргийн 7-19 дүгээр хорооны 18-35 насны зорилтод бүлгийн нийт 195 залуучууд оролцлоо.

Гэр бүлийн сарын аян болгон зарласантай холбогдуулан хороодын иргэний танхимаар дамжуулан гэр бүлийн үнэ цэнэ, гэр бүлийн гишүүдийн харилцааны ёс зүй, гэр бүл төлөвлөлт сэдвийн хүрээнд “Гэр бүлийн үнэ цэнэ” илтгэлийн уралдааныг Чингэлтэй дүүргийн Хүүхэд, гэр бүл хөгжлийн төвтэй хамтран зохион байгууллаа. Тус уралдаанд дүүргийн 18-35 насны залуучууд оролцсон ба гэр бүл дэх Аавын үүрэг, Хүүхдийн оролцоо, Аз жаргалтай гэр бүл сэдвийн хүрээнд шилдэг 15 илтгэл тавигдаж, байр эзлүүлэн өргөмжлөл, үнэ бүхий зүйлээс шагнаж урамшуулсан байна.

“Олон Улсын эмэгтэйчүүдийн өдөр”-ийг тохиолдуулан “Залуу эмэгтэйчүүдийн манлайлал” сэдэвт сургалтыг хороодын Иргэний танхимаар дамжуулан зохион байгууллаа. Сургалтанд дүүргийн 18-35 насны эмэгтэйчүүд хамрагдсан бөгөөд

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал “Эмэгтэйчүүдийн эрх ба нийгэм дэх оролцоо”, “Залуу эмэгтэйн гоо зүй, ур чадвар” “Эмэгтэйчүүдийн оролцоо ба манлайлал багийн ажиллагаа” сэдвийн хүрээнд зохион байгуулагдлаа.

Уг арга хэмжээнд Чингэлтэй дүүргийн 19 хорооны нийт 900 гаруй иргэн хамрагдсан байна.

Уламжлал болгон зохион байгуулагддаг “Өглөг буяны өдөр”-ийг Түвдэнпэлжээлин хийдтэй хамтран зохион байгууллаа. Тус өдөрлөгт дүүргийн нэн ядуу, эмзэг бүлгийн иргэд оролцсон бөгөөд засал, буяны ном хурж, будаалга өгч, хүнсний болон эд материалын туслалцаа үзүүллээ. Тус арга хэмжээнд дүүргийн нэн ядуу, эмзэг бүлгийн төлөөлөл 190 иргэн оролцсон.

Нийгмийн зорилтод бүлэгрүү чиглэсэн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилтын хүрээнд Монголын үлгэр жишээ сургалт, судалгааны төв ТББ-тай хамтран “Дүүргийн хөгжилд залуусын оролцоо” сэдэвт сургалтыг дүүргийн 18-35 насны залуучуудын дунд зохион байгууллаа. Сургалтанд дүүргийн 19 хорооны 570 гаруй залуучууд хамрагдсан ба “Амжилттай суралцахуй”, “Илтгэх чадвараа нэмэгдүүлэх нь”, “Төсөл хөтөлбөр бичих арга зүй”, “Манлайлах урлаг ба лидерийн зарчим”, “Зорилго түүнд хүрэх арга зам”, “Сошиал медиа маркетинг”, “Оролцоо ба оролдлого” зэрэг сэдвийн хүрээнд сургалт, лекц, ярилцлага хэлбэрээр зохион байгууллаа.

Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн өдөрт зориулан Шатрын спортыг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Дүүргийн шатар сонирхогчдын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, эрэгтэй 6, эмэгтэй 3 тамирчныг Нийслэлийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхийн бичиг, мөнгөн шагналаар урамшуулав.

Ахмад настны талаар баримтлах төрийн бодлогын хүрээнд нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн ахмад настанд тавих анхаарал халамжийг өндөржүүлэх, тэдний бүтээлч ажиллах идэвх санаачилгыг өрнүүлэх зорилгоор Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн “Ахмад настанд ээлтэй байгууллага, иргэн шалгаруулах журам” батлагдсан.

Энэ журмын хүрээнд Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Ахмадын хороо хамтран жил бүр “Ахмад настанд ээлтэй байгууллага, иргэн”-ийг шалгаруулдаг уламжлалтай. 2016 онд тус үйл ажиллагааны хүрээнд дүүргийн Ахмадын хороонд хороо, Ахмадын зөвлөлөөсөө тодорхойлогдож ирсэн байгууллага, иргэний үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцан ахмад настанд ээлтэй 3 байгууллага, 3 иргэнийг шалгаруулан шагнаж урамшуулсан.

“Ахмад настанд ээлтэй байгууллага”-аар Дүүргийн 2 дугаар хорооны “Мянгат” СӨХ, 11 дүгээр хорооны “Эж-Эрдэнэ”ХХК, 17 дугаар хорооны “Камел” Хүнсний дэлгүүр, “Ахмад настанд ээлтэй иргэн”-ээр дүүргийн 5 дугаар хорооны иргэн Д.Цэвээнсүрэн, 14 дүгээр хорооны иргэн С.Пандий, 19 дүгээр хорооны иргэн Б.Даринчулуун нарыг тус тус шалгаруулж Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл, мөнгөн шагнал” гардуулсан.

Дөрөв. ХУРЛЫН ДОТООД АЖИЛ, БАЙГУУЛЛАГА, ИРГЭДТЭЙ АЖИЛЛАСАН ТАЛААР:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу Хурлын Ажлын алба нь Хурал,

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

Тэргүүлэгчдийн бодлого зорилтын хэрэгжилтийг зохион байгуулах, Хурлын хороодын хуралдааны бэлтгэл ажил, хуралдаанаас гарах шийдвэрийн төсөл боловсруулан батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, Хурлын Төлөөлөгчдийн хуралдаа ажиллах нөхцөл бололцоог хангах, техник, зохион байгуулалт, арга зүйн туслалцаа үзүүлэх, Хурал, Тэргүүлэгчдээс зохион байгуулсан ажлыг иргэд, олон нийтэд сурталчлах, хурал, төвлөрсөн болон хяналт шалгалтын бусад арга хэмжээг зохион байгуулах, Хурлын байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, төсөв санхүү зэрэг хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах чиг үүргийн дагуу ажиллаж байна.

Тайлант хугацаанд Хурлын дарга эрх хэмжээнийхээ хүрээнд Хурлын Ажлын албаны үйл ажиллагаатай холбогдолтой асуудлаар нийт 42 захирамж, Хурлын Тэргүүлэгчдийн Нарийн бичгийн дарга эрх хэмжээнийхээ хүрээнд 173 тушаал гаргаж Хурал, Тэргүүлэгчдээс батлан гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан.

Хурлын Ажлын албанаас батлагдан гарч буй захирамжлалын болон зохион байгуулалт, мэдээлэл лавлагааны баримт бичгүүдийг архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу гаргаж, тайлангийн хугацаанд байгууллага, иргэдээс нийт 131 албан бичиг тоот хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэснээс гадна ажил хэргийн шугмаар дээд шатны болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд 290 албан бичиг явуулсан байна.

Тайлангийн хугацаанд Хурал, Тэргүүлэгчид түүний Ажлын албанд нийт 40 өргөдөл, гомдол ирүүлснийг ангилбал: Санхүүгийн тусламж хүссэн-18, Нийгмийн халамж, Төрийн үйлчилгээ хүссэн-14, дэд бүтэц, газартай холбоотой-4, гомдол 3, талархал 1 байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдлийг Нийслэлийн нэгдсэн өргөдөл, гомдлын сайт www.smartcity.mn цахим сайтад бүртгэн, 4 өргөдлийг Хурлын Ажлын алба бүрэн шийдвэрлэж, 36 өргөдлийг Засаг даргын Тамгын газар түүний харьяа хэлтэс албадад цахимаар болон албан тоотоор шилжүүлснээс 17 өргөдлийг шийдвэрлэн, 9 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна.

Улсын Их Хурлын өргөдлийн байнгын хорооны “Өргөдөл хүлээн авах журам”-ын хэрэгжилтийг хангах, УИХ түүний Өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдлийг саналын хайрцагаар дамжуулан хүлээн авах зорилгоор дүүргийн нэг цэгийн үйлчилгээний танхимд өргөдлийн хайрцагийг байршуулж, хорооны Иргэний танхимд тус журмыг сурталчилах ажлыг зохион байгууллаа.

Тайлант хугацаанд саналын хайрцагаар 1 өргөдөл ирүүлсэнийг УИХ-ын Өргөдлийн байнгын хороонд шилжүүлэн өгсөн.

Албан хэрэг хөтлөлтийг “Төрийн албан хэрэг хөтлөлтийн заавар”, журмын дагуу явуулах чиглэлийн хүрээнд 2016 оны 06 дугаар сараас “Нийслэлийн цахим архив” төсөл нь төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг цахим, тоон хэлбэрт хувиргах, төгөлдөржүүлэх зорилгоор нэвтрүүлсэн Албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаанд тоон технологи нэвтрүүлсэн нэгдсэн системд байгууллагууд шилжиж, баримт бичгийг цахимаар хүлээн авч шийдвэрлэдэг боллоо.

Байгууллагын тасралтгүй суралцах үйл ажиллагааг хангах, ажилтнуудын ажил үүргээ гүйцэтгэх мэдлэг, ур чадвар, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Хурлын Ажлын албаны ажилтнуудад зохион байгуулах жилийн сургалтын төлөвлөгөөг боловсруулан Ажлын албаны даргаар батлуулан ажилласан байна.

Сургалтын хөтөлбөрийн дагуу BZP digital & Inbound MARKETING ХХК-тай хамтран “Сошиал медиа маркетинг” сэдвээр сургалт, “Тунгаамал” ТББ-тай хамтран “ИТХ-аас батлах эрх зүйн баримт бичгийг боловсруулах аргачлал” гэсэн сэдвээр, мөн Германы эрдэмтэн Ким Мэрил Бишофтай хамтран “Хувь хүний санаачлага” сэдвээр тус тус сургалтуудыг зохион байгуулсан.

Төрийн албан хаагчдын мэдлэг ур чадварыг сайжруулах ажлын хүрээнд Хууль зүйн үндсэний хүрээлэнтэй хамтран Захиргааны ерөнхий хууль, Лэди төвтэй хамтран “Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлага” сэдвүүдээр тус тус сургалтуудыг зохион байгуулав.

Тайлант хугацаанд анхан шатны баримт бичгийн бүрдэлд үндэслэн, нийт 500 зарлагын гүйлгээг хийж гүйцэтгэсэн ба байгууллагыг аж ахуйн шаардлагатай эд материалаар ханган, эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хариуцан, бараа, хангамж, бичиг хэргийн материал, мөнгөн гүйлгээний орлого, зарлагын тайлан гарган ажиллаж, төсвийн ил тод байдлыг хангах хүрээнд санхүүгийн мэдээг Хурлын веб хуудас болон шилэн дансанд хуулийн хугацаанд тогтмол байршуулж ажиллалаа.

Нийслэлийн өмчийн харилцааны газраар 2015 онд байгуулсан гэрээний биелэлт 91% буюу "А" үнэлгээтэй дүгнүүлсэн байна.

Нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс дүүрэг хөгжүүлэх үйлсэд бодит хувь нэмэр оруулан хариуцсан ажилдаа амжилт гарган ажиллаж байгаа нийт 703 иргэнийг дүүргийн Хурлын шагналаар шагнаж урамшуулсан байна.

Төрийн цол, одон медалиар шагнуулахаар байгууллага, хамт олноосоо тодорхойлогдож ирсэн 470 хүний шагналын тодорхойлолт, Алдарт эх 1, 2 дугаар зэргийн одонгоор шагнуулахаар ирүүлсэн 300 эхийн материалыг тус тус Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжилсан байна.

Хууль зүйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын баталсан удирдамжийн дагуу тус дүүргийн нутаг дэвсгэрт байрлах шашны байгууллага болон бусад ТББ, хуулийн этгээдийн талаар дэлгэрэнгүй судаллагааг гарган бүртгэлжүүлэх, шашны төрөл, урсгал чиглэл, байршил, бусад үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх арга хэмжээг зохион байгуулж, шашны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө сунгуулахар ирүүлсэн 13 сүм хийдийн холбогдох материалыг хянан үзээд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжилсан.

Монгол улсын Авилгын эсрэг хууль болон холбогдох журмын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд Авлигын эсрэг хууль тогтоомж, холбогдох журамд өөрчлөлт орсонтой холбогдуулан хөрөнгө орлогын мэдүүлэг гаргачдын нэрсийн жагсаалтыг шинэчлэн гаргаж, мэдүүлэг гаргагч нарт хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг цахимаар мэдүүлж, цаасаар бүртгүүлэх тухай гарын авлагаар хангаж, тайлант онд 47 албан тушаалтны мэдүүлгийг цахимаар хүлээн авч, бүртгэн, хуулийн хугацаанд нь тайлан мэдээг хүргүүлж ажиллалаа.

Тав. ГАДААД ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, үр өгөөжтэй нэгдмэл байх зарчмыг хэрэгжүүлэх, ижил төстэй байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох, харилцан туршлага солилцох, сайн туршлагыг дүүрэг орон нутагт хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Нутгийн өөрөө удирдах байгууллагуудтай ажил төрлийн холбоо тогтоох, дүүргийн хөгжлийн бодлогын асуудлаар ижил төстэй байгууллагуудын ажлын туршлагыг судлаж өөрийн ажилдаа нэвтрүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2016 онд гадаад, дотоод харилцаагаа өргөжүүлэх зорилт тавьж, энэ чиглэлээр дараах ажлыг зохион байгуулсан.

Тайлангийн хугацаанд найрамдалт харилцаат бүхий Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотын Сонгбук, Сунгпа дүүрэг, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хот Ардын Төлөөлөгчдийн Хурал, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Манжуур хотын Ардын Тэргүүлэгчдийн Хуралтай байнгын харилцаатай ажиллалаа.

Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Бүгд найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах орны Манжуур хотын Ардын Төлөөлөгчдийн Хурлын хооронд нийгэм, эдийн засгийн бүхий л асуудлаар харилцан тохиролцож, хамтын ажиллагааны харилцан ойлголцлын Санамж бичгийг байгуулахаар тохиролцсон.

БНСУ-ын Инчон хотын Ёнсу дүүргийн хамтын ажиллагааны хүрээнд Хурлын дарга Пак тэргүүтэй Хурлын төлөөлөгч, Ажлын албаны ажилтнууд нийт 17 хүний бүрэлдэхүүнтэй зочид дүүрэгт айлчлал хийж, цаашид харилцаа холбоогоо бататгах талаар санал солилцсон юм.

Зургаа. ГЭМТ ХЭРГЭЭС УРДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид өө.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь дүүргийн иргэдийн эрх ашиг хүсэл сонирхолыг илэрхийлж, дүүргийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтыг тодорхойлон иргэд, хамт олны бүтээлч санаачлага, идэвхтэй оролцоог эрхэмлэн дэмжиж, сонгогчдынхоо итгэл найдварыг дээдлэн хүндэтгэж нутгийн өөрөөр удирдах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх өргөжүүлэн хөгжүүлэхийг эрхэм зорилго болгон ажиллах нь чухал.

Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, дүүргийнхээ нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилтыг иргэдийнхээ эрх ашиг, хүсэл сонирхолтой уялдуулан тодорхойлж, хэрэгжилтийг хангахад хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Цаашид дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагаас Нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийн хугацаандаа хуулиар хариуцуулсан үүрэг болон дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт нэг бүрийг бүрэн хэрэгжүүлэхийн төлөө ажиллаж байна.

ТАЙЛАН ХЯНАСАН:

АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

Ц.АЛТАНЦАЦРАЛ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХУРЛЫН ДОТООД АЖИЛ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ
ХАРИУЦСАН АЖИЛТАН Б.СОЛОНГО